

## **“БЭРХ УУЛ” ХК-ИЙН 2018 ОНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

“Бэрх Уул” ХК нь 2018 онд нүүрс олборлон борлуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулсан.

### **1. Чандганы нүүрсний уурхай:**

Чандганы нүүрсний уурхайн ТЭЗҮ-ийн нэмэлт тодотголыг 2017 оны 11-р сарын 03-нд ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, АМГТГ-ын даргын 2017 оны 12-р сарын 28-ны өдрийн Т/123 тоот тушаалаар батлан, хүлээн авсан. Батлагдсан ТЭЗҮ-ийн нэмэлт тодотголыг үндэслэн Чандганы нүүрсний уурхайн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголыг 2018 оны 12-р сарын 12-ны БОАЖЯамны хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулсан.

ТЭЗҮ-ийн нэмэлт тодотголд тутгагдсанаар Чандганы нүүрсний уурхайд 2018 онд 23509 м<sup>3</sup> хөрс хуулж, 26750 тонн нүүрс олборлох төлөвлөгөөтэй байсныг 2018 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган баталгаажуулсан. Гэсэн хэдий ч 2018 оны нүүрс борлуулалт болон Хэнтий аймгийн төвлөрсөн халаалтын зуухнууд нэмэгдсэн зэргийг харгалзан үзээд 220000 м<sup>3</sup> хөрс хуулж, 26510 м<sup>3</sup> хөрс цэвэрлэгээний ажлыг нэмж гүйцэтгэн Хэнтий аймаг болон бусад сумдын хэрэглэгчдийн хэрэгцээнд 51740.5 тонн нүүрс олборлон борлуулалт хийсэн.

Өнгөрсөн жилийн хувьд хөрс хуулалтын ажлыг 7-р сарын 20-оос 09-р сарын 20-ны хооронд гүйцэтгэхээр төлөвлөсөн хэдий ч зарим аж ахуйн нэгж, байгууллагууд төсөвт суусан халаалтын зардал дууссан, төсөвт байгууллагаас авах халаалтын авлагаа авч чадахгүй байна гэдэг тайлбартайгаар 7-р сарын 20-ны байдлаар нэлээдгүй хэмжээний өртэй гарсан. Иймээс 2018 онд хуулах хөрсийг 7-р сард эхлэх байсан хэдий ч дээрхи авлагын асуудлаас болоод 2017-2018 оны халаалтын улиралд ажиллах техникийн урсгал засварын ажил болон хөрс хуулалтын ажил төлөвлөгөөний дагуу эхэлж чадахгүйд хүрсэн.

Дээрхи аж ахуйн нэгж, байгууллагуудаас авлагаа цаг тухайд нь авч чадаагүйн улмаас техникүүдийн урсгал засвар болон хөрс хуулалтын ажил хойшлогдож, орон нутгийн өвөлжилтийн байдалд хүндрэл учрах эрсдэлтэй байсан тул хөрс хуулалтын ажлыг “Арвижих бэрх” ХХК-иар гүйцэтгүүлэн 220000 м<sup>3</sup> хөрс хуулалтын ажлыг 8-р сарын 10-аас 10-р сарын 01-нд бүрэн хуулж дууссан.

Тайлант онд уурхайн гол техникүүд болох KOMATSU-D155A бульдозерт явах ангид урсгал засвар, DOOSAN эксковаторын моторт их засвар, ZL50C-автоачигчийн моторт урсгал засварын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Чандганы нүүрсний уурхайн 2018 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд 10.561 сая төгрөг зарцуулна гэж төлөвлөснөөс 7.871 сая төгрөг зарцуулан ажилласан.

## **2. Тусгай зөвшөөрлийн тухай:**

Тус компани нь MV-04590, MV-00166, MV-10965 гэсэн ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг эзэмшиж байгаа бөгөөд уг тусгай зөвшөөрлүүдийн төлбөр хугацаандаа төлөгдөн явж байна.

## **3. Боловсон хүчний тухай:**

2018 онд тус компани нь Захиргааны хэсэгт-9 ажилчин, Чандганы нүүрсний уурхайн хэсэгт-7 ажилчин, Харуулын албаны хэсэгт-13 ажилчин гэсэн бүрэлдэхүүнтэйгээр, нийт 29 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс эмэгтэй-13, эрэгтэй-16.

МШӨ-ний групптэй-2, энгийн групптэй-1, ахмад настан-4 эдгээр ажиллагсадыг эрүүл мэндэд харшлахгүй хөнгөн ажлаар ханган ажиллаж байна.

Тус компани нь “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг боловсруулан үйл ажиллагаанд мөрдлөг болгож, 2 жил тутам шинэжилдэг. Мөн байгууллагын Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд Хамтын гэрээ байгуулан ажиллаж жил тутам дүгнэж баталгаажуулан ажиллаж байна.

Ажил олгогчийн зүгээс ажилтан бүртэй Хөдөлмөрийн гэрээ байгуулж, шинээр орсон ажилтантай 3 сар хүртэл туршилтын гэрээ байгуулан ажиллуулдаг. Мөн ажиллагсдын цалинг сар бүрийн сүүлийн 7 хоногт олгож, нийгмийн даатгалын дэвтэрт үнэн зөв бичилт хийн баталгаажуулж байна.

Чандганы уурхайн ажилчдыг 2 жил тутам хөдөлмөрийн нөхцөл, ажил үүргийн онцлогт тохируулан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын тусгай хувцсаар хангаж, хор саармагжуулах сүү, аарц, чацарганы шүүсийг хоол хүнсэндээ тогтмол хэрэглэж байна.

“Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм зааварчилгаа”-г байгууллагын онцлогт тохируулан боловсруулж мөрдөж, ажилчдад ХХАА-ны дүрэм журмыг тогтмол өгч, гарын үсгээр баталгаажуулан ажилладаг.

## **4. Санхүү:**

### **Компанийн 2018 оны орлого үр дүнгийн тайлан, баланс**

2018 оны байдлаар 51,740.5 тн нүүрс борлуулж 1,149,02 сая төгрөг, нүүрс тээврийн орлого нь 4,9 сая төгрөг, түрээсийн орлого 2,2 сая, жоншны шороо борлуулсаны орлого 64,1 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгө борлуулсаны олз 23,7 сая төгрөг, харилцах дансанд бодогдсон хүүгийн орлого 0,38 сая тус тус олсон байна. Нүүрс борлуулахад гарсан ББӨ 932,0 сая төгрөг,

үйл ажиллагааны зардалд 543,8, сая төгрөг, санхүүгийн зардал 2,123.34 сая төгрөг, валютын ханшийн зөрүүний алдагдал (2,354.8) сая төгрөг болж, нийт энэ онд (4,519.1) төгрөгийн алдагдалтай ажилласан.

Орлого үр дүнгийн тайлан	Хэмжих нэгж	2017 он	2018 он
Борлуулалт	сая. төг	1,148.74	1,149.02
ББӨ	сая. төг	971.15	932.00
Нийт ашиг	сая. төг	177.59	217.02
Бусад орлого	сая. төг	7.04	95.30
Ерөнхий удирдлагын зардал	сая. төг	508.75	543.83
Санхүүгийн зардал	сая. төг	2,087.86	2,123.34
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	сая. төг	(2,411.98)	(2,354.85)
Үйл ажиллагааны бус ашиг (алдагдал)	сая. төг	(19.03)	(20.61)
Валютын ханшийн зөрүүний ашиг (алдагдал)	сая. төг	534.47	(2,143.60)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	сая. төг	(1,896.54)	(4,519.06)
Орлогын татварын зардал	сая. төг	0.05	0.04
Татварын дараах ашиг (алдагдал)	сая. төг	(1,896.59)	(4,519.10)

№	Хураангуй баланс	2017.12.31	2018.12.31
1	<b>ХӨРӨНГӨ:</b>		
2	Эргэлтийн хөрөнгө	297.36	140.12
3	Эргэлтийн бус хөрөнгө	12,182.67	14,006.95
4	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>12,480.03</b>	<b>14,147.07</b>
5	<b>ӨР ТӨЛБӨР:</b>		
6	Богино хугацаат өр төлбөр	9,415.04	14,720.58
7	Урт хугацаат өр төлбөр	28,833.01	29,615.30
8	<b>ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН:</b>	<b>38,248.05</b>	<b>44,335.88</b>
9	<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>		
10	Хувийн өмч	1,906.21	1,906.21
11	Дахин үнэлгээний нэмэгдэл		1,990.69
12	Хуримтлагдсан ашиг	-27,674.23	-34,085.70
13	<b>ЭЗДИЙН ӨМЧИЙН НИЙТ ДҮН</b>	<b>-25,768.02</b>	<b>-30,188.81</b>
14	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>12,480.03</b>	<b>14,147.07</b>

**Чандганы нүүрсний үүрхайн хэсэг:**

2018 онд Чандганы нүүрсний уурхай нь хөрс хуулалтын ажлыг “Арвижих бэрх” ХХК-иар амжилттай гүйцэтгүүлсэн. Нүүрсний борлуулалт болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ашиг алдагдлыг сүүлийн 3 жилээр тооцож үзвэл

№	Төрөл	Хэмжих нэгж	2016	2017	2018
1	Нүүрсний борлуулалт тн	тн	42,281.5	54,669.0	51,740.5
2	Нүүрсний борлуулалт /төг/	сая.төг	890.55	1,148.74	1,149.02
3	ББӨ	сая.төг	543.00	971.15	932.0
4	Нийт ашиг	сая.төг	347.55	177.59	217.02

**2018 оны татвар, нийгмийн даатгаын шимтгэл:**

Компани нь санхүүгийн тайлан баланс болон нийгмийн даатгалын тайланг хуульд заасан хугацаанд цаг тухайд нь гаргаж, аж ахуй нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр болон нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд заасан цаг хугацаанд нь төлж барагдуулж байгаа. 2018 онд татварт 153,1 сая төгрөг төлж 91,6 сая төгрөгийн өртэй, мөн нийгмийн даатгалын шимтгэлд 99,2 сая төгрөг төлж 35,4 сая төгрөгийн өртэй гарсан.

№	Татварын төрөл	2018 оны эхний үлд	Үүссэн	Төлсөн	2018 оны 12.31 үлд
1	Агаарын бохирдол		25,870,250	25,870,250	-
2	АМНАТ		28,725,415	28,725,415	-
3	ААНОАТ				-
4	НӨАТ	38,897,776	63,431,740	50,570,936	51,758,580
5	ХАОАТ	38,500,448	38,376,439	38,500,448	38,376,439
6	Суутган 10		1,910,889	426,222	1,484,667
7	АТӨЯХАТ		655,000	655,000	-
8	АТӨЯХАБТ		86,600	86,600	
9	ҮХХАТ		6,455,398	6,455,398	-
10	Газрын төлбөр / Бэрх /		82,300	82,300	-
11	Газрын төлбөр / Дэлгэрхаан /		917,440	917,440	-
12	Газрын төлбөр / Чандган /		720,000	720,000	-
13	Бууны татвар		120,000	120,000	-
14	НД-н шимтгэл	35,756,093	98,926,762	99,212,518	35,470,337
Нийт дүн		113,154,317	266,278,232	252,342,527	127,090,023
Татвар НДШ-н хураангуй					
№	Татварын төрөл	Эхний үлд	Үүссэн	Төлсөн	Эцсийн үлд
1	Татвар	77,398,224	167,351,470	153,130,009	91,619,686
2	НД-н шимтгэл	35,756,093	98,926,762	99,212,518	35,470,337
Нийт дүн		113,154,317	266,278,232	252,342,527	127,090,023